



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/97

Улаанбаатар хот

**Улаанбаатар хотын захирагчийн ажлын
албаны балансаас хөрөнгө шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2020 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 3,507,690.0 /гурван сая таван зуун долоон мянга зургаан зуун ерэн/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Улаанбаатар зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ-ын балансад шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба /Т.Гантөмөр/-д зөвшөөрсүгэй.

2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж авахыг Улаанбаатар зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ /Б.Баянмөнх/-т даалгасугай.

3. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба /Т.Гантөмөр/-д, Улаанбаатар зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ /Б.Баянмөнх/-т тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.


ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

115 / 0 100225

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
 газрын даргын 2020 оны дугаар
 сарын өдрийн тоот тушаалын хавсралт



Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба

Д/д	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэн авах байгууллага
1. Машин тоног төхөөрөмж										
1	Компьютер	Acer	2008.06.30	Ш	1	935,100	935,100	935,100	-	Улаанбаатар зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ
2	Компьютер	Dell 19 LSD	2009.12.31	Ш	1	922,900	922,900	922,900	-	
3	Компьютер	Lenovo 2000	2008.10.31	Ш	1	948,990	948,990	948,990	-	
4	Компьютер	PC	2008.12.31	Ш	1	700,700	700,700	700,700	-	
Тоног төхөөрөмжийн дүн					4		3,507,690	3,507,690	-	